

3

**МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ХУРДАСГАХ ЗАРИМ АСУУДАЛ**

**Т.Дорж, Н.Сонинтамир**

Эдийн засгийн ухаанд эдийн засгийн өсөлтийн асуудал гол байр суурь эзэлдэг. Учир нь нэг хүнд оногдох ДНБ, ҮНБ-ий өсөлт нь хүн амын амьдралын түвшний дээшлэлтийг үзүүлэхийн дээр бас бодит бүтээгдэхүүний өсөлтийг илэрхийлж, зардал хэмнэх зарчимд нийцдэг. Нөгөө талаар өсөн нэмэгдэж байгаа нийгэм эдийн засгийн хэрэгцээг хангах, нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг дотоод гадаадад шийдвэрлэх чадавч өндөр байхын чацуу тухайн үеийн хэрэгцээг хангах боломжийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж улмаар дэд бүтэц, боловсрол, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах болон бас бусад салбарт хөрөнгө оруулж түүний үр дагавараар улс орны хөгжлийн түвшин дээшлэх нөхцлийг бүрдүүлдэг.

Эдийн засгийн онолоор бол нэг талаас бүрэн ажил эрхлэлтийн хангах, нөгөө талаар үйлдвэрлэлийн хүчин зүйлийг дээд зэргээр ашиглах гэсэн хоорондоо салшгүй холбоотой хоёр асуудал байдаг бөгөөд үүнээс үүдэн эдийн засгийн өсөлтийг ямарваа нэг тодорхой хугацааны бодит ҮНБ буюу эсвэл ҮЦБ-ий өсөлт, эсвэл ямарваа тодорхой хугацаанд нэг хүн амд ногдох бодит ҮНБ буюу ҮЦБ-ий өсөлт өөрөөр хэлбэл хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт гэж ойлгодог.

Эдийн засгийн өсөлтийг хангах нь орчин үеийн төрийн гол үүргүүдийн нэг бөгөөд, түүний хэрэгжилт нь төрийн бусад үүргүүд амжилттай шийдвэрлэгдэх үндсэн нэг нөхцөл нь болдог. Монгол орны хувьд эдийн засгийн өсөлтийг хангах замаар хүн ардынхаа амьдралын түвшинг дээшлүүлэх явдал нэг чухал зорилт юм.

Аливаа улс хөгжин дэвших, хямарч будилах, уруудан дордох түүхийн хүрдийн эрээнтэй бараантай, гэрэлтэй гэгээтэй янз бүрийн замыг гэтлэн туулж өнөөгийн хөгжлийн түвшинд хүрсэн түүхтэй. Монгол улс нэгдэл, задрал, бутрал, колонийн дарлал мөлжлөгийг дамжин сүүлдээ төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн замаар замнасаар өнөөгийн төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд хөл тавьж хямралтай учирсан юм. Нийгмийн нэг тогтолцоог нөгөө тогтолцоогоор солигдоход хямрал дагалддаг жамтай ба манай орны хувьд дээрх төвлөрсөн төлөвлөгөөт удирдлагатай эдийн засгаас төрийн зохицуулалттай

зах зээлийн эдийн засагт шилжихтэй холбогдож үүссэн түүхтэй. Гэхдээ улс төрийн болон бусад хүчин зүйлс нөлөөлснийг үгүйсгэх аргагүй. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед уламжилалт мал аж ахуй, шинэ тутам хөгжсөн газар тариалан, аж үйлдвэрийн зарим салбар, тээвэр, холбоо үүсэн хөгжиж байсан ч хуучин ЗХУ-аас хараат байдал Европын социалист зарим оронтой тогтоосон харилцаа нь манай орны эдийн засаг хавсарга шинж бүхий бүтэц бүрэлдэхэд хүргэжээ. Ийм эдийн засаг үр ашиг багатай, өөрийгөө тэтгэх чадваргүй байдаг учир хүн амын амжиргааны түвшин хөгжиж байгаа орнуудынхтай харьцуулахад нилээд доогуур байгаа юм. Манай гадаадаас авч байсан зээл тусламж үндэсний орлогын 30 гаруй хувьтай тэнцэж, энэ нь монголчуудын өөрийн хүч чадлаар хөгжиж амьдрах биш, бусдын хүчинд дулдуйдах, бусдаар тэжээлгэн тэтгүүлж амьдрахыг бишрэн шүтэхэд хүргэж, тэдэнд бэлэнчлэх сэтгэлгээг төлөвшүүлжээ. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг өөрчлөхөд Монгол оронд хөгжлийн ээдрээтэй үе эхэлж, эдийн засгийн өөрийн бодит болоцооны хирээр амьдрах түвшин 1993 он хүртлэх буурах процесс явагдсан. Дотоод чадавхиараа өөрийгөө тэтгэн, нөхөн сэргээж, хөгжих чадваргүй бүтэцтэй байсан эдийн засаг, тэтгүүлж байсан гадаад орчноосоо салж, өөрийн амьдрах бодит түвшиндээ хүртэл буурсан юм. Ийм учраас манай эдийн засаг бодит байдлаасаа түрүүлж хөгжлийн нийтлэг зарчим дээр тогтворжин хөгжих боломжгүй. Эдийн засгийн бууралтын үе шат өнгөрсний дараа тогтворжих, өсөх үе эхлэх учиртай. Харин ийм үе шатууд амьдрах гадаад орныхоо хувьд урьдынхаасаа эрс ялгаатай цоо шинэ хүрээнд очихын зэрэгцээ ажиллагаа нь механизмын хувьд урьдынхаасаа цоо шинэ байх нь мэдээж. Монголын эдийн засаг 1993 оноос тогтворжин өсөх хандлага ажиглагдаж эхэлсэн ч одоо хүртэл өөдтэй бодит тууштай өсөлт хараахан гараагүй байна.

Хэдийгээр хөгжлийн шинж тэмдэг илэрч буй ч энэ нь эдийн засгийн өнөөгийн хөгжил дэх бэрхшээлүүдийг хаацайлах учиргүй. 1990 оноос одоог хүртэл Монголын хүн ам жил бүр 1.4-1.6% орчмоор өссөн байхад эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдэд буурсаар 2000 онд 1.1% болсон байна. 1993-2000 онд ДНБ-ний өсөлт жилд дунджаар 3 орчим хувьтай байсан ч сүүлийн 7 жилд нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ нийт дүнгээр 17%, жилийн дундаж өсөлт ердөө 2 илүү хувь байсан байна. 2000 оныг 1987 онтой харьцуулахад ДНБ 22 хувиар доогуур байна.

Монгол улс Хөгжлийн Албан Ёсны Туслалцаа (ХАЁТ)-аас ихээхэн хараат байдалтай байна. 1990 онд шилжилтийн үеийн эхэнд (ХАЁТ) ДНБ-ний дунджаар 24 хувьтай тэнцэж байв (Хүснэгт №1). Олон улсын стандартаар энэ нь туйлын өндөр үзүүлэлт юм. 1990-ээд оны эхээр гадаадын зээл тусламж ДНБ-ний 30 хувиас ч давж байв. 1991-2000 оны хооронд Монголд үзүүлсэн (ХАЁТ) бараг 1.9 тэрбум ам доллартай тэнцэж байгаа нь 2 сая 400 мянган хүн амтай орны хувьд маш өндөр тоо юм.

Хүснэгт №1

(ХАЁТ)-ийн ач холбогдол

Он	/ХАЁТ/-ын ДНБ-д эзлэх хувь	Нэг хүнд ногдох /ХАЁТ/ ам доллар
1991	20	45
1992	33	68
1993	36	93
1994	25	77
1995	18	99
1996	18	90
1997	25	113
1998	21	84
1999	24	81
2000	17	67

Эх сурвалж: Санхүү Эдийн Засгийн Яам

Хэрвээ (ХАЁТ)-ийг ашиглан сайн хөрөнгө оруулалт хийж чадсан бол улс орон өнөөдөр хурдацтай хөгжих боломжтой байсан ч эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдэд удааширсаар 2000 онд 1.1% болж, МАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл бараг 20 хувиар буурч, үр тарианы үйлдвэрлэл ч бас унасан юм. Үүний шалтгаан нь сүүлийн жилүүдэд удаа дараа тохиосон байгалийн гамшигт үзэгдлүүд үндсэн шалтгааны нэг боловч асуудлын мөн чанар түүнээс ч гүнд байх бөгөөд нийгмийн бодлогоор зохицуулах ёстой.

Хэрвээ гадаадын зээл тусламжийг хөгжлийн зорилгод сайтар ашиглаж чадсан бол эдийн засгийн өсөлтөөр Монгол улс гадаадын зээл, тусламжаас хараат байдлын талаар асуудал өрнүүлэх учиргүйсэн.

Монгол дэлхийн улс орнуудын зээл тусламжаас хараат байдлаараа (ХАЁТ)-ийн ДНБ-д эзлэх хувиараа 5-р байранд тэргүүлж явна. Хүснэгт 2-т үзүүлснээр 1998 онд ДНБ-д тусламжийн эзлэх хувь 21 хувьтай, 90-ээд онд нийтэд нь арай дээгүүр буюу 24 хувийн дундаж үзүүлэлттэй байжээ. Бага орлоготой орнуудын хувьд үүний дундаж үзүүлэлт 1.3%, дундаж орлоготой орнуудын хувьд маш бага 0.4 хувьтай л байдаг юм. Монгол улс гадаадын зээл тусламжийг хүртэхийн хувьд төдийлөн бахархалтай бус, харин хачирхалтай нөхцөлд байгаагаа ухаарах нь зүй.

Монгол болон шилжилтийн үед буй өөр нэг улс бол Лаос хоёр зээл тусламжаас хамгийн хараат 5 улсын тоонд багтаж байна. Эхний 3 байранд Мозамбик, Никарагуа, Малави гурав л орж байгаагийн аль альных нь хувьд дотоод хадгаламжийн түвшин доогуур байдаг.

Хүснэгт №2

Зээл тусламжаас хамгийн хараат таван орон

Он	ҮНБ-д /ХАЁТ/-ын эзлэх хувь /1998/	ДНБ-д дотоод хадгаламжийн эзлэх хувь /1999/
Мозамбик	28.2	11
Никарагуа	28.1	1
Малави	24.4	7
Лаос	23.0	24
Монгол	20.6	20
Бага орлоготой орнууд	1.3	19
Дундаж орлоготой орнууд	0.4	26

Эдийн засгийн өсөлтөнд гадаадын шууд хөрөнгө оруулалт чухал үүрэгтэй. Албан ёсны статистик мэдээнд тулгуурлавал, 90-ээд онд Монгол дотоодын хөрөнгө оруулалт нэмэгджээ. Хэдийгээр 1989 оны түвшиндээ хүрээгүй байгаа ч ДНБ-д хөрөнгө оруулалтын эзлэх хувь сүүлийн жилүүдэд өсч иржээ. 1995 онд хөрөнгө оруулалт ДНБ-ий 16 хувьтай тэнцэж байсан бол 2000 онд бараг 25 хувьтай тэнцэх болсон байна (Хүснэгт №3). Хэрвээ тоон мэдээ зөв бол хөрөнгийн нөөц нэмэгдэж байгааг харуулж байгаа учир нааштай төлөв байдал ажиглагдаж байгаа хэрэг.

Ямар ч байсан одоогоор Монгол улс хөрөнгө оруулалтын санхүүжилтээ өөрийн хувийн хөрөнгөнд бус харин гадаадын зээл тусламжид тулгуурлаж ирсэн байна.

Хөрөнгө оруулалтын үүрэг  
(ДНБ-д эзлэх хувиар)

Хөрөнгө оруулалтын хэлбэр	1995	1996	1997	1998	1999	2000
Гадаадын шууд хөрөнгө оруулалт /ГШХО/	0.8	1.7	2.0	2.1	3.5	4.2
Дотоод хөрөнгө оруулалт	15.7	20.3	20.7	23.7	25.6	24.7

Эх сурвалж: Санхүү Эдийн Засгийн Яам

Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь 90-ээд оны дунд үеэс л маш бага хэмжээгээр нэмэгдэж иржээ. Хүснэгт №3-т үзүүлснээр Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь ДНБ-ий дөнгөж 4%-тай тэнцэж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь ихэвчлэн өсөж байгаа эдийн засагт чиглэгддэг учраас энэ нь нэг их гайхмаар зүйл биш юм. Байгалийн арвин нөөцтэй л биш бол гадаадын шууд хөрөнгө оруулагчид эдийн засгийн өсөлтийн сөрөг буюу тун доогуур үзүүлэлттэй эдийн засагт том хэмжээний хөрөнгө оруулдаггүй билээ.

Зарим улс орнуудын хөгжил нь гадаад хөрөнгө оруулалтыг хэр зэрэг татахаас шалтгаалдаг хэмээн итгэсээр байдаг. Гэвч бодит байдал дээр энэ нь зэрэг буюу гадаадын шууд хөрөнгө оруулалт нь ихэвчлэн нэгэнт бий болсон эдийн засгийн өсөлтөнд суурилагаас ирээдүйн өсөлтөд найддаггүй юм. Шилжилтийн үеийн эдийн засгийн хурдацтай өсөлтийг бий болгон гадаадын томоохон шууд хөрөнгө оруулалтыг татаж чадсан улсууд бол БНХАУ болон Вьетнам юм. Өсөлтийг хурдасгах гол хүчин зүйл нь дотоод хадгаламж, хөрөнгө оруулалт байсан байна. Хятадад 1999 онд дотоодын хөрөнгө оруулалт ДНБ-ий 40%-ийг эзэлж байсан бол хадгаламжийн эзлэх хувь түүнээс ч өндөр 42%-тай байв. Үүнтэй харьцуулахад ХАЁТ ДНБ-ий дөнгөж 0.3%-тай тэнцүү, харин гадаад өр 15%-тай тэнцүү байна. Хятад илүү хурдан хөгжиж чадсан бөгөөд ингэхдээ гадаадын зээл тусламжинд найдаагүй юм.

Байгалийн баялаг нөөцтэй бусад орнуудтай адил Монголд орж ирж байгаа гадаадын хөрөнгө оруулалт уул уурхайд голчлон чиглэгдсэнгүй. 2000 онд гадаадын шууд хөрөнгө оруулалтын дөнгөж 15%-ийг л уул уурхайн салбар эзэлж байжээ. Энэ нь 90-ээд оныхоос ч буураад байгаа үзүүлэлт юм (Хүснэгт 4). Мөн МАА-н бүтээгдэхүүний хувьд ч байдал адил байна. Харин хөнгөн үйлдвэр, хүнсний үйлдвэрлэлийн салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалт 90-ээд онд өсөж иржээ. 2000 оны байдлаар хөнгөн үйлдвэр гадаадын шууд хөрөнгө оруулалтын хамгийн том хувийг буюу 27%-ийг эзэлсэн байна.

Хүснэгт №4

ГШХО-ыг салбараар үзүүлсэн байдал  
(нийтэд эзлэх хувь)

Салбар	1990-2001 /хагас жилээр/	2000
Уул уурхай	22.4	15.5
Хөнгөн үйлдвэр	17.8	26.7
МАА-н бүтээгдэхүүн	9.9	5.9
Хүнсний үйлдвэрлэл	9.4	14.7
Барилга	8.7	7.4

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хийж буй орнуудыг анхааралтай судлан үзвэл ихэд санаандгүй зүйлийг олж мэдэх болно. Хүснэгт №5-аас үзвэл 1995 онд Япон улсаас үзүүлсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт 23% байснаа огцом буурсныг харж болно. Гэвч энэ бууралт 90-ээд оны төгсгөлд тохиолдсон учир нийт хувь нь 12%-тай байна. Мөн ОХУ эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан тус улсад оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсанд гайхах явдалгүй юм.

Хүснэгт №5

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг улсаар үзүүлсэн байдал

Улс	1995	1990-2002 /хагас жилээр/
БНХАУ	8.6	28.6
БНСУ	8.0	13.4
Япон	23.2	11.7
АНУ	7.5	7.3
ОХУ	17.4	6.0
Хонг конг	0.8	4.3

Харин БНСУ, БНХАУ-аас оруулж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт ондоо дүр зургийг харуулж байна. 1995 онд Өмнөд Солонгос улс гадаадын шууд хөрөнгө оруулалтын 8%-ийг оруулж байсан бол сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр 90-ээд оны нийт хөрөнгө оруулалт дунджаар 13%-тай байна. 1995 онд гадаадын шууд хөрөнгө оруулалтанд Хятад улсын эзлэх хувь Солонгосынхтой ижил байсан ч сүүлийн таван жилд огцом нэмэгдэж Хятад улс дангаараа нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 29%-ийг эзлэх болсон нь бусад улсуудын эзэлж байгаатай харьцуулахгүй өндөр юм. Хонг Конгоос оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтыг Хятадынхтай нийлүүлэхэд 31%-иар нэмэгджээ. Хятад улс Монголын хувьд төдийлэн нэрд гараагүй ч чухал хөрөнгө оруулагч болох нь тодорхой харагдаж байна.

**Хөгжлийн албан ёсны туслалцаа болон Гадаадын шууд хөрөнгө оруулалт өөрчлөлт гаргаж чадсан уу?**

Хэрэв Хөгжлийн албан ёсны туслалцаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалт нь Монголын эдийн засгийг өөрчлөж чадсан бол дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэх байлаа. Монголын хувьд гадаадын зээл тусламжийн шууд ба шууд бус нөлөө нь хэрэглээг тэтгэж байснаас хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж олгосонгүй.

Хөрөнгө оруулалтад дотоодын хадгаламжийн оруулсан хувь нэмрийг Хөгжлийн албан ёсны туслалцаа ба гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийлбэрийг нийт хөрөнгө оруулалтаас хасах маягаар тоймлон шууд бусаар тооцоолж болох юм. Энэ нь санхүүгийн хөрөнгө оруулалтад дотоодын эдийн засгийн оруулсан хувь нэмэр гэсэн үг. Хүснэгт №6-д 1995-2000 оны хооронд дээрх тооцоо ямар үр дүнг үзүүлж байгааг харуулав. Дээрх зургаан жилийн 3-т нь хөрөнгө оруулах дотоод хувь нэмэр сөрөг үзүүлэлттэй 2-т нь тэг орчимд гарч байна. Албан ёсны статистик мэдээнд үзүүлсний эсрэгээр Монголын дотоод хадгаламжийн түвшин дөнгөж зэрэг үзүүлэлттэй гарвал л хамгийн том амжилт агаад магадгүй цэвэр хадгаламж нь сөрөгч үзүүлэлттэй байж болзошгүй. Иймээс гадаад хадгаламж дотоод хадгаламжийг хазаарлаж байна.

Гадаадын хөрөнгийн урсгал болон Монгол дахь дотоод хөрөнгө оруулалт, 1995-2000 (ДНБ-д эзлэх хувиар)

Он	Гадаадын хөрөнгийн урсгал	Дотоод хөрөнгө оруулалт	Хөрөнгө оруулалтын санхүүжилтэнд дотоодын хөрөнгийн эзлэх хувь
1995	19.2	15.7	-3.5
1996	19.5	20.3	0.8
1997	27.4	20.7	-6.7
1998	22.8	23.7	0.9
1999	27.6	25.6	-2.0
2000	21.4	24.7	3.3

Тайлбар:

1. Гадаадын хөрөнгийн урсгал нь ХАЁТ болон ГШХО-ыг хамарна.
2. Хөрөнгө оруулалт гэдэг нь нийт хөрөнгө оруулалт бөгөөд хөрөнгийн элэгдлийг оролцуулаагүй болно.
3. Хөрөнгө оруулалтын санхүүжилтэд оруулах дотоод хувь нэмэр гэдэг нь нийт хөрөнгө оруулалт, гадаад урсгал хоёрын хоорондын ялгаа бөгөөд хадгаламжийн түвшинг ойролцоогоор илэрхийлдэг гэж ойлгож болно.

Гадаадын зээл тусламжаас их хэмжээгээр хараат байх нь гадаад өрийг нэмэгдүүлдэг. Монголын гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь сүүлийн жилүүдэд өссөөр ирлээ. Хүснэгт №7-д харуулж байгаагаар 1997 онд энэ түвшин 60 орчим хувьтай байсан бол 2001 онд бараг 90%-тай болох төлөвтэй. Энэ нь сүүлийн 4 жилийн дотор гадаад өр 50 орчим хувь нэмэгдсэн гэсэн үг юм. Мөн хугацаанд экспорт тогтворгүй байсан байна. 2001 онд экспортын өсөлт ердөө 3%-тай байх төлөвтэй. Монголын экспортын үйлдвэрлэл гадаад зах зээл дээр итгэлтэй хөл тавьж, алдан байдгийн нэг шалтгаан нь их хэмжээний зээл тусламж нь валютын ханшийг хөөрөгдсөнтэй холбоотой. Тиймээс Монголд гадаад өрөө төлөх валютын нөөцийг бий болгох нь хүнд рэлтэй. Түүнчлэн нэг хүнд ногдох орлогын өсөлт сүүлийн жилүүдэд удааширч 2000 онд бага зэргийн сөрөг үзүүлэлттэй гарсан бол 2001 онд тэг орчимд байх төлөвтэй. Тиймээс гадаадын зээл нь гадаад өрөө төлөх бүтээгдэхүүн үйлдвэрлэл, орлогыг бий болгож чадахгүй байх аюултай юм. Хэрэглээгээ хангахын тулд л ихээр зээл авна гэдэг маш аюултай стратеги юм.

Монголын хувьд нэг давуу тал нь ихэвчлэн олон талт болон хоёр талт хамтын ажиллагааны хандивлагч байгууллагуудын хөнгөлөлттэй зээлийг авч ашиглаж иржээ. Ийм зээл нь арилжааны зээлийг бодвол бага хүүтэй, удаан хугацаатай байдаг. Гэвч Монгол улс энэ зээлийг эргүүлэн төлөх шаардлагатай тулгарч л таарна. Хэрвээ эдийн засгийн өсөлт, экспортын үйлдвэрлэл өнөөгийн байдалдаа хэвийн байх юм бол зээлийг буцаан төлөх нь туйлын хүнд болох бөгөөд тэр цагт улс орны хувь заяа сүүлийн арван жилийн дотор томоохон зээлийг өгсөн АХБ нийт зээлийн 32%, Япон улс нийт зээлийн 21%, Дэлхийн банк нийт зээлийн 14%, Герман, ОХУ, Хятад, Норвеги нилээд нийт зээлийн 12%, арилжааны зээлийн 20 орчим хувийг эзэлсэн гэсэн хандивлагчдын гарт орох нь байна. Хэдийгээр олон талт хандивлагчид зээлийнхээ тал хувийг хэрэгсэхгүй болсон ч Монгол улсын өр яваандаа хүчингүй гэсэн үзэл бодолд тулгуурлан бодлогоо боловсруулж болохгүй.

Монгол улс гадаадын хөрөнгийн томоохон урсгал, худалдааны чөлөөлөлт нь өсөлт, хөгжлийг бий болгоно хэмээн найдсан. Гол хандивлагчдын үзэж байгаагаар дэлхийн эдийн засагт татагдан орох нь Монголын эдийн засгийн хувьд амин чухал асуудал юм. Хаалттай эдийн

засаг хэрэгтэй хэмээн маргавал инээдтэй сонсогдох нь мэдээж ч ялангуяа шилжилтийн эхэн үед эдийн засгийг бүрэн нээлттэй болгосноор өсөлтийг бий болгоно хэмээн найдах нь утгагүй. Үнэндээ Монголын хувьд ч нийт хөгжиж буй орнуудын хувьд ч худалдааны чөлөөлөлт, эдийн засгийн өсөлт хоёрын хооронд шууд хамаарал ажиглагддаггүй. Олон улсын туршлагаас харахад гадны туршлагыг хуулбарласнаар хурдтай өсөлтийг бий болгосон нь ховор байдаг. Үүний оронд дотоодын байгууллага, институцын үүсгэл санаачлага, дотоодын санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн эдийн засгийн шинэчлэл нь өсөлтийг нэмэгдүүлдэг.

Гадаад өр, экспортын өсөлтийн түвшин, нэг хүнд ногдох орлогыг харьцуулсан нь (нийтэд эзлэх хувь)

Он	Гадаад өр / ДНБ-д эзлэх хувь /	Экспорт / жилийн хувь /	Нэг хүнд ногдох орлого / жилийн хувь /
1997	60.7	22.9	2.6
1998	77.6	-18.7	2.1
1999	93.6	-1.7	1.8
2000	80.0	17.4	-0.3
2001	89.9	3.1	0.0

Тайлбар: 2001 оны хувьд гадаад өр, нэг хүнд ногдох орлогын хэмжээ нь төсөвлөгдсөн байдлаар тусгагдсан байна.

Монголын хувьд атаархаад байхааргүй нөхцөл байна. Энэ улс зээл тусламжаас дэндүү хараат болж хоцорчээ. Иймээс дотоодын хадгаламжийн түвшин сөрөг биш юм гэхэд туйлын доогуур үзүүлэлттэй байна. Гадаадын зээл тусламж дотоодын хадгаламжийн байр суурийг эзэлж, дотоодын хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх хэрэгсэл болж байна. Эдийн засгийн өсөлт тасалдаж, экспортын үйлдвэрлэл маш их хэлбэлзэлтэй байна. Өсөлт, экспортын үйлдвэрлэл байхгүй нөхцөлд улс орны гадаад өр нэмэгдсээр байх тодорхой хугацааны дараа өрийн хямрал бүрхэх болно.

Энэ бүхнээс зайлсхийхийн тулд Засгийн газар хадгаламжийг нэмэгдүүлж, бодит байгалийн нөөцийн болон хүний хүчин зүйлсийн хөрөнгө оруулалтад дотоодын санхүүжилттэй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд хамгийн нэн тэргүүний ач холбогдлыг өгөх нь зүйтэй.

Дээрх судалгаанаас үзэхэд:

1. Монгол орон зээл тусламжаасаа хараат байдлаараа дэлхийд тавдугаарт орж байна. Хэрэв нэгэнт авсан зээл тусламжийн хэмжээг нь авч үзвэл улс орны хөгжил ахиц урагштай байхаар боловч бодит байдалд нэг хүнд ногдох орлогын өсөлт удаан, сүүлийн таван жилд эдийн засгийн өсөлт буурсан байна.
2. Улс орны хөгжлийг хурдасгах хэрэглүүр байх гадаадын зээл тусламж нь тухайн үеийн хэрэглээг хангахад чиглэгдэж дотоодын хадгаламжийн орон зайг эзэлж ирсэн.
3. Улсын салбарын хадгаламж сөрөг үзүүлэлттэй байгаа бөгөөд төсвийн их хэмжээний алдагдлыг гадаадын зээл тусламжаар нөхөж ирсэн. Эндээс үзэхэд зээл тусламж нь татварын орлогын орон зайг эзэлж иржээ.
4. Гадаадын их хэмжээний зээл тусламж байсан ч түүний хэсэг нь шууд хөрөнгө оруулалтад зориулагдаж тэр нь эдийн засгийн өсөлтийг төдийлөн хангаж чадахгүй байна.
5. Зочид буудалд болж буй хурал семинар тэнд ирж оролцогч зочид төлөөлөгчид зээл тусламжаар санхүүжигдэж, мэргэжилтэн төлөөлөгчдийн зардал мөн л зээл тусламжаар

санхүүжигдэж, санхүүжигчдийн зээл тусламж тодорхой хэсэг нь буцаад гараад явдаг нь тодорхой.

6. Монгол их хэмжээний тусламж, хөнгөлөлттэй зээл авсанаараа азтай. Тэгэхдээ гадаад өр хурдацтайгаар нэмэгдсээр өрийн хямралд орох нь тодорхой эдийн засгийг өсгөж, экспортыг нэмэгдүүлэхгүй юм бол өрөө төлөх валютын нөөцгүй болох нь тодорхой.
7. Гадаадын зээл тусламжийн орж ирж буй урсгал нэмэгдэхэд валютын ханш өсдөг. Манай экспортын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар нь буурч, дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, импортын бараатай өрсөлдөх чадвар сул болдог. Ер нь гадаадын орж ирж буй зээл тусламж экспортын эрчимтэй хөгжлийг оролдог.

Энэ байдлаас гарах арга зам бол эдийн засгийн оновчтой стратеги боловсруулж хэрэгжүүлэх явдал юм.

### Монголын эдийн засгийн хөгжлийн стратеги ямар байх вэ?

Стратеги бол аливаа байгууллага хөгжиж амжилт, үр дүнд хүрэх арга болж байдаг болохоор Монголчуудын эрхэмлэх удаан хугацааны гол зорилго бол улс төр, эдийн засгийн хувьд бие даасан орчин үеийн өндөр технологид түшиглэсэн зохистой бүтэц бүхий аж үйлдвэр, өндөр өсөлт бүхий хөдөө аж ахуйтай, уламжилалт байгалийн унаган төрхөө хадгалсан өөрөө өөрийгөө тэтгэх эдийн засагтай улс орон болох явдал юм.

Өөрийгөө тэтгэх чадвартай эдийн засагтай болох Монгол орны зорилго дараах эдийн засгийн бодлогуудыг хэрэгжүүлснээр биелэх үндэстэй гэж үзнэ.

Эхний үед манай орон ДНБ-ий хэрэгцээгээ бүрэн хангахгүй байгаа учраас шаардлагатай хөрөнгө оруулалт болон гадаад худалдааны алдагдлыг нөхөхөд санхүүжилтийн гадаад хуримтлалын эх үүсвэр зайлшгүй шаардлагатай.

Дараагийн шатанд үндэсний дотоодын нийт бүтээгдэхүүн өсөж, энэ нь дотоод хуримтлал бий болгож өсөх нөхцөл боломж бүрэлдэх бөгөөд ингэснээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа гадаадын хараат байдлаас ангижирч, гадаад худалдааны баланс сайжирна.

Сүүлийн шатанд ДНБ илүү хурдацтайгаар өсөж, улс орны дотоод хуримтлалын сонирхол төлөвшин нэмэгдэж, гадаадаас авсан өр зээлийг төлөхөд хүрэлцэхүйц хэмжээний гадаад худалдааны илүүдэлтэй болно.

Дээрх үзэл баримтлалыг үндэс болгон Монголын эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж үзсэн юм. Ингэхдээ Монголын макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг шинжлэх, прогнозчилох зориулалтаар бидний боловсруулсан салбар хоорондын балансын динамик загвар (экспортын максималчлал, зорилгын функц бүхий) ашигласан юм. Хавсралтыг үзнэ үү.

### Загварын үр дүн

Монгол орон дээрхи үзэл баримтлалыг хэрэгжүүлэхдээ хүн төрөлхтөний иргэншлийн ирээдүй өөрийн орны нөхцөл өв уламжлал, хөгжлийн боломжийг харгалзан үзэх нь мэдээж юм. Бидний судалгаагаар 1990-2000 он бол эдийн засгийн уналт, тогтворжилт сэргэлтийн үе бөгөөд энэ үе шатанд уналтыг гэтлэн давах, улмаар зогсоож, тогтворжуулан цаашдын хөгжлийн үндсэн суурийг тавих зорилгыг хэрэгжүүлж байна. Үүнээс гадна энэ үеийн сүүлчээр өөрөөр хэлбэл 2000 оноос эдийн засгийн өөрөө бие дааж хөгжих нөхцлийг бүрдүүлэх нэг үгээр хэлбэл эдийн

засгийн хөгжилд нөлөөтэй тэргүүлэх салбарыг бүрэлдүүлэхэд, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг чиглүүлэх хандлага юм. Давамгайлах төлөвтэй энэ шатанд ДНБ-ий өсөлт 3% орчим байх төлөвтэй. 2001-2010 онд эдийн засгийн тэргүүлэх салбарууд тэргүүлэх технологид суурилсан алхам хийж, эдийн засгийн хурдацыг нэмэгдүүлэн ҮНБ-ий жилийн дундаж өсөлт 5% болгож, 2010-2020 онуудад ДНБ-ий өсөлт 8%-д хүрч, нэг хүнд ногдох ҮНБ 1700 ам.доллар хүрч, улсын эдийн засгийн үр ашигтай бүтцийг үндсэндээ бий болгож, өөрийгөө тэтгэх эдийн засагтай болох төлөвтэй.

Гэхдээ эдийн засгийн хөгжлийн динамикийг зохистойгоор хадгалах нь мэдээж. Өөрийгөө тэтгэн хөгжих чадвартай эдийн засагтай болоход шийдвэрлэх нэг нөхцөл бол нийгэм эдийн засгийн зөв стратеги тактик боловсруулж түүнийгээ барих явдал юм. Олон ургальч үзлийг иш үндэс болгон, орчин үеийн шинжлэх ухааны аргуудыг ашиглан монгол орны хөгжлийн стратегийг олон хувилбараар боловсруулж, тэдгээрийг хооронд нь уралдуулж, илүү сайныг нь сонгон шалгаруулж, түүний цаг хугацааны хувьд хэсэгчлэн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байх журам тогтоох шаардлагатай байна. Түүнээс биш нэг нам түр засгийн өндөрлөгт гарангуут шинэ стратеги гаргаж түүнийг хэрэгжүүлэхийн төлөө биш, харин урьд өмнө ул үндэстэй боловсруулж, бүгд хүлээн зөвшөөрч баталсан стратегийг хэрэгжүүлэхийн төлөө ажиллах нь зүйтэй болов уу. Чингэвээс ард олноос сонгогдон байгуулагдах парламент засгийн газрын үйл ажиллагааны өвлөн залгамжлах чанар, уламжлал шинэчлэлийн зарчим хэрэгжиж, дэвшүүлэн тавьсан зорилгоо хэрэгжүүлэхээр цаг хугацаа хожин, хөрөнгө ариг гамтай зарцуулж, хөгжил дэвшлийн өндөрлөгт хүрэх боломжтой. Оновчтой стратеги тактикийн зэрэгцээ гадаадын хөрөнгө оруулалтын хөхүүлэн дэмжих учиртай. Ингэхдээ Монголд хөрөнгөө оруулах сонирхолтой байгууллага, хүмүүсийг судлах хөрөнгө оруулах чадвартай гадаадын улс, пүүс, хүмүүсийн дунд сурталчилгааны ажил явуулбал зохино. Гадаадын хөрөнгө оруулалтыг эдийн засгийн өсөлтөнд үр ашигтайгаар нөлөөлөх эдийн засгийн бүтэц бүрэлдэн бий болгоход чиглүүлэх бодлого барих хэрэгтэй. Нөгөө талаар хөрөнгө оруулалтын үр ашгийг түүнийг оруулсан улс, пүүс, компани, шууд өөрийн орон руу гуйвуулах боломж хангах чадвартай гэдгээ гадны улс орны өмнө батлан харуулах, ийм үүргээ найдвартай биелүүлэх банкны чадварыг ч дээшлүүлбэл уг зорилт хэрэгжих үндэстэй. Засгийн газраас мөнгө санхүүгийн алсын хараатай маш үр дүнтэй бодлого явуулах үндсэн дээр үнэ валютын ханшны тогтвортой байдлыг хангах шаардлагатай. Хөгжлийн алс хэтийн стратегийн хүрээнд эдийн засгийн өсөлт хөгжил мастер төлөвлөгөөгөө боловсруулж түүнийгээ мөрдөх явдал чухал байна. Уг төлөвлөгөө нь засгийн газраас явуулах бодлого, арга хэмжээнээс гадна макро салбар, орон нутгийн болон микро эдийн засгийн хүрээнд авч явуулах бодлого арга хэмжээг цаг хугацааны нарийн дэс дараалал, нөөцийн эх үүсвэрийн хувиартайгаар тусгах нь зүйтэй гэж үзэж байна.